



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 14/03

Баянбулаг

“БАХАРХАЛ” шагнал олгох
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.17 дахь заалтуудыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 14 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын Газрын дээд “Бахархал” шагнал олгох журмыг нэгдүгээр хавсралтаар, нэр дэвшигчийн товч танилцуулгын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Шагналын цогцолборыг журамд заасан хэмжээ, загварыг сумын нэр дээр патентлуулж оюуны өмчид бүртгүүлж, гэрчилгээжүүлэх ажлыг (Засаг дарга) Н.Гансүхэд даалгасугай.

3.Журмын хэрэгжилтийг хангаж, журмыг нийтэд сурталчилж ажиллахыг сумын (Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд ажлын албаны дарга) Ц.Цэндэд үүрэг болгосугай.

ДАРГА

Б.НАМГАРРЕНЧИН



648803079

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 20²³ оны
03 сарын 31 өдрийн ээлжит дүгээр хуралдааны
14/03 дугаар тогтоолын дүгээр хавсралт

БАЯНЦАГААН СУМЫН ДЭЭД “БАХАРХАЛ” ШАГНАЛ,
ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Баянцагаан сумын бүтээн байгуулалт, хөгжил дэвшилт, нийгэм эдийн засгийн бүхий л салбарт дахин давтагдашгүй, ховор, гоц гарамгай амжилт гаргасан, нутаг орноо Монгол улс, Олон Улсын түвшинд сурталчилсан, улс болон тив дэлхийн түвшинд үнэлэгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, шинэ технологи, оюуны бүтээлийг бий болгосон иргэн, аж ахуйн нэгжийг шагнаж урамшуулахтай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

2. Шагналын бүрэлдэхүүн

2.1. “Бахархал” нь Баянцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын Газрын хамтарсан сумын дээд шагнал мөн.

2.2. “Бахархал” гэдэг нь Баянцагаан сумын хөдөлмөрч, бүтээлч ард түмний түүхэндээ Буман мал сүрэг тоолуулж, Түмэн хурга бойжуулж 1974, 1975 онуудад төрөөс хүртсэн ган тулгатай галын дөл бадарсан Таван хошуу малын баримал хөшөөний дурсгалын хувилбар, түүний гол багана хэсэгт 2021 онд МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээсэн Алтангадас одонг байрлуулсан сумын шагналын цогцолбор байна.

2.3. Бахархалын суурь нь 19 см урттай, 7 см өндөр 4 талтай дөрвөлжин байх бөгөөд суурийн урд талд Баянхонгор Баянцагаан сум Бахархал гэсэн бичвэртэй, хажуу хоёр талд сумын нутаг дэвсгэрийн зураг Баянхайрхан уулын дүрслэл байна. Тус суурийн голд 27 см өндөр, 3 см диаметртэй багана байх ба баганыг тойруулсан 5 хошуу эцэг малын баримал байна. Баганын гол хэсэгт Алтангадас одонгийн хуулбар хувь байх бөгөөд тус шагналын цогцолбор нь гадуураа шилэн хорготой байна.

2.4. Тус “Бахархал”-ийг сумын Засаг даргын “Захирамж”, “Хүндэт Өргөмжлөл”, 1.000.000 [нэг сая] төгрөг дагалдана. “Хүндэт Өргөмжлөл”-ийг монгол бичгээр бичсэн байна.

2.5. Шагналын материалын зардал 1.000.000 [нэг сая] төгрөг байна.

3.Шагналд нэр дэвшигчид тавигдах шаардлага

3.1.Шагналыг доорх шалгууруудын болзлыг бүрэн биелүүлсэн иргэн, аж ахуйн нэгжид олгоно.

3.1.1."Бахархал" шагналыг Баянцагаан сумын харьят болон уугул иргэдэд олгоно. Тавигдах шалгуурыг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших амжилт бүтээлээр дүгнэнэ.

3.2.Иргэнд тавигдах шаардлага.

3.2.1.Монгол улс, Тив, Дэлхийд өөрийн болон нутаг орны нэрийг өндөрт мандуулсан дахин давтагдашгүй амжилт гаргасан иргэн.

3.2.2.Гоц, гарамгай оюуны болон эрдэм шинжилгээний бүтээл турвисан иргэн.

3.2.3.Сумын нийгэм, здийн засгийн салбаруудад үнэтэй хөрөнгө оруулалт хийсэн, хандивлагч, олноор ажлын байр бий болгогч иргэн.

3.2.4.Сумын хүний хөгжил, боловсрол, эрүүл мэнд, хүүхдийн ирээдүйд бодитой нөлөөлөхүйц ажил арга хэмжээг үр дүнтэй, давтамжтай зохион байгуулж нутагшуулсан иргэн.

3.2.5.Сумын Хөдөө аж ахуйн салбарт үр бүтээлтэй ажиллаж малын чанар, үүлдрийг өөрийн бэлчээрийн бүсчлэлийн хэмжээнд сайжруулж, олон айл өрхүүдийг бодитой малжуулсан, атар газар эзэмшиж үр дүнтэй тариалалт эрхэлсэн, байгальд ээлтэй, нийгэм, здийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан нь төр, иргэдэд үнэлэгдэн нийтэд үр өгөөжөө өгсөн иргэн.

3.2.6.Сумын нийгэм здийн засаг, нийгмийг хөгжүүлэх үйлсэд олон жилийн хөдөлмөрийн үр шимээ зориулж, орон нутагтаа тогтвортой суурьшилтай амьдарч, бусдад хүлээн зөвшөөрөгдөхүйц ажлын санал санаачилга гарган хэрэгжүүлж, тасралтгүй амжилт гаргасан нэр хүндтэй төрийн албан хаагч, иргэдийг 3 жил тутамд 1 удаа.

3.3.Аж ахуйн нэгжид тавигдах шаардлага.

3.3.1.Аж ахуйн нэгж гэдэгт Төрийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, хоршоод, компани, төрийн бус байгууллагуудыг хамруулж ойлгоно. Амжилт бүтээлийг сум орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалт, иргэдэд зориулж хийсэн үйл ажиллагаагаар тооцно.

3.3.2. Цөлжилт, хуурайшилтын эсрэг сумын нутаг дэвсгэр дээр ногоон байгууламж нэмэгдүүлэх, баянбүрд байгуулах, байгаль орчныг хамгаалах чиглэлээр үр дүнд хүрсэн бодитой ажил хийсэн аж ахуйн нэгж.

3.3.3. Сумын хүн амын боловсрол, эрүүл мэнд, соёл, спортом онцгой ач холбогдол болохуйц уулзалт, сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, үр дүнд хүргэсэн аж ахуйн нэгж.

3.3.4. Сумын төвд оршин суугч иргэдийн эрүүл, аюулгүй амьдрах орчинд бодитой нөлөөлөхуйц бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгж.

3.3.5. Сумын нийгэм, эдийн засгийн салбаруудад үнэтэй хөрөнгө оруулалт хийсэн, хандивлагч, олноор ажлын байр бий болгогч аж ахуйн нэгж.

4. Шагналд нэр дэвшүүлэх

4.1. Шагналд нэр дэвшүүлэх хүсэлт, тодорхойлолтыг тухайн иргэний баг, байгууллага, нутгийн зөвлөл, иргэний төлөөлөл нь гаргаж дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

4.1.1. Нэр дэвшигчийн анкет, мэдүүлэг (2-р хавсралтаар)

4.1.2. Хамт олны хурлын тэмдэглэл

4.1.3. Нэр дэвшигчийн ажил байдал, амжилтын үзүүлэлтийн тухай тодорхойлолт

4.2. Дээрх баримт, бичгийг бүрдүүлж тухайн жилийн Монголчуудын уламжлалт сар шинийн баярын өдрөөс 21-с доошгүй хоногийн өмнө сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлнэ.

4.3. Тус шагналд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Сумын Засаг дарга иргэн, аж ахуйн нэгжийг нэр дэвшүүлж болно.

5. Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, гардуулах

5.1. Шагнуулах хүсэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн хүлээн авч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

5.2.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь энэхүү журмын 4 дэх хэсэгт заасан шагналд нэр дэвшүүлэх шаардлагыг хангаж байгаа 1 шагналын материалыг албажуулан сумын Засаг даргад хүргүүлнэ.

5.3.Сумын Засаг дарга хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Захирамж гарган шагналын бүрэлдэхүүнийг бэлтгэж, холбогдох зардлыг нөөц хөрөнгөөсөө зарцуулна.

5.4.Шагналыг жил бүрийн билгийн улирлын тооллын хаврын тэргүүн сарын Сар шинийн баярыг угтан гардуулна.

5.5.Тус “Бахархал” шагналаар шагнагдсан иргэд, аж ахуйн нэгжийн зураг, танилцуулгыг сумын төсөвт албан байгууллага, багууд албан газартаа байрлуулж нийтэд сурталчлан таниулан, хүндэтгэн дээдэлнэ. Зурагт танилцуулга нь 40x60 см хэмжээтэй нэгэн ижил загвар, хийцтэй байна.

6.Шагналын дурсгалын бахархал, Захирамж, Өргөмжлөлийг нөхөн болон сольж олгох

6.1.Сумын “Бахархал” шагналын дурсгалын баримал, Захирамж, Өргөмжлөлийг аливаа шалтгаанаар үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн түүний нөхөр, эхнэр, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү нөхөн болон сольж авахыг хүсвэл эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл, үнийн дүнт тушаасан баримт, эвдэрч гэмтсэн баримал, Захирамж, Өргөмжлөлийн хамт ажлын албанд ирүүлнэ.

6.2.Ажлын алба өргөдлийг хянан үзэж сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл холбогдох удирдлагуудад уламжлан нөхөн олгоно.

7.Бусад зүйл

7.1.Шагналд зарцуулагдах хөрөнгийг төлөвлөж жил бүр Засаг даргын нөөц хөрөнгөд тусгаж байна.

7.2.Шагнагдсан иргэдийн болон шагнуулахаар ирүүлсэн иргэдийн нэрс, материалыг үрэгдүүлэхгүй архивлан хадгална.

8.Журамд нэмэлт өөрчлөлт оруулах

8.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн болон Засаг дарга, Засаг даргын тамгын газрын саналаар журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны
 03 сарын 31. өдрийн ээлжит 17. дүгээр хуралдааны
 14/оздугаар тогтоолын 02. дугаар хавсралт

Шагналд нэр дэвшигчийн анкет



1. Овог
2. Нэр
3. Төрсөн огноо
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот:
6. Одоогийн харьяалал:
7. Регистрийн №
8. Боловсрол:
9. Ажилладаг салбар:
10. Мэргэжил:
11. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1	2	3	4
1			
2			
3			
4			
5			
6			

12. Урьд нь шагнагдаж байсан салбарын болон Төрийн шагналууд:

№	Шагналын нэр	Хэдэн онд
1	2	3
1		
2		
3		
4		
5		
6		

- 13.Хамт олны саналын хувь:
- 14.Шагнуулах үндэслэл, ажлын үзүүлэлтийг хавсаргах
15. Утасны дугаар:
- 16.Тодорхойлолт гаргасан хүний нэр:Гарын үсэг:.....
(Баг, байгууллага, аж ахуйн нэгж бол тамга, тэмдэг дарах)
- 17.Он сар өдөр:

4.Шагналд нэр дэвшүүлэх

4.1.Шагналд нэр дэвшүүлэх хүсэлт, тодорхойлолтыг тухайн иргэний баг, байгууллага, нутгийн зөвлөл, иргэний төлөөлөл нь гаргаж дараах бичиг баримтыг бүрдүүлсэн байна.

4.1.1.Нэр дэвшигчийн анкет, мэдүүлэг (2-р хавсралтаар)

4.1.2.Хамт олны хурлын тэмдэглэл

4.1.3.Нэр дэвшигчийн ажил байдал, амжилтын үзүүлэлтийн тухай тодорхойлолт

4.2.Дээрх баримт, бичгийг бүрдүүлж тухайн жилийн Монголчуудын уламжлалт сар шинийн баярын өдрөөс 21-с доошгүй хоногийн өмнө сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд ирүүлнэ.

4.3.Тус шагналд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Сумын Засаг дарга иргэн, аж ахуйн нэгжийг нэр дэвшүүлж болно.

5.Шагнуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, гардуулах

5.1.Шагнуулах хүсэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны мэргэжилтэн хүлээн авч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргад танилцуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

5.2.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь энэхүү журмын 4 дэх хэсэгт заасан шагналд нэр дэвшүүлэх шаардлагыг хангаж байгаа 1 шагналын материалыг албажуулан сумын Засаг даргад хүргүүлнэ.

5.3.Сумын Засаг дарга хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Захирамж гарган шагналын бүрэлдэхүүнийг бэлтгэж, холбогдох зардлыг нөөц хөрөнгөөсөө зарцуулна.

5.4.Шагналыг жил бүрийн билгийн улирлын тооллын хаврын тэргүүн сарын Сар шинийн баярыг угтан гардуулна.

5.5.Тус “Бахархал” шагналаар шагнагдсан иргэд, аж ахуйн нэгжийн зураг, танилцуулгыг сумын төсөвт албан байгууллага, багууд албан газартаа байрлуулж нийтэд сурталчлан таниулан, хүндэтгэн дээдэлнэ. Зурагт танилцуулга нь 40x60 см хэмжээтэй нэгэн ижил загвар, хийцтэй байна.

6.Шагналын дурсгалын бахархал, Захирамж, Өргөмжлөлийг нөхөн болон сольж олгох

6.1.Сумын “Бахархал” шагналын дурсгалын баримал, Захирамж, Өргөмжлөлийг аливаа шалтгаанаар үрэгдүүлсэн, гээгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн түүний нөхөр, эхнэр, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү нөхөн болон сольж авахыг хүсвэл эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл, үнийн дүнг тушаасан баримт, эвдэрч гэмтсэн баримал, Захирамж, Өргөмжлөлийн хамт ажлын албанд ирүүлнэ.

6.2.Ажлын алба өргөдлийг хянан үзэж сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл холбогдох удирдлагуудад уламжлан нөхөн олгоно.

7.Бусад зүйл

7.1.Шагналд зарцуулагдах хөрөнгийг төлөвлөж жил бүр Засаг даргын нөөц хөрөнгөд тусгаж байна.

7.2.Шагнагдсан иргэдийн болон шагнуулахаар ирүүлсэн иргэдийн нэрс, материалыг үрэгдүүлэхгүй архивлан хадгална.

8.Журамд нэмэлт өөрчлөлт оруулах

8.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн болон Засаг дарга, Засаг даргын тамгын газрын саналаар журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцэнэ.